

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Зарим тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсгийг нэмсүгэй:

1/ “1.3. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүнийг Хороонд бүртгүүлнэ. Хороонд бүртгүүлээгүй бол тухайн даатгалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглоно” гэж.

2. Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1, 2.10 дахь заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “2.1. Даатгагч дараах нөөцийн сангуудыг даатгалын хэлбэр тус бүрээр байгуулна” гэж;

3. Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.10 дахь хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “хэлбэр” гэж өөрчилсүгэй.

4. Хорооны 2007 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар”-ын 2.3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “2.3.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон ердийн даатгалын хэлбэрт хамаарагдах даатгалын бүтээгдэхүүний гэрээ болон баталгаа боловсруулж гаргах” гэж.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н. Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ